



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 627

Улаанбаатар хот

Загвар, аргачлал, маягт батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 4.9 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матриц”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга”-ыг гуравдугаар хавсралтаар, “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлдэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлан, мэдээний загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлан, мэдээг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.6, 4.1.7-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-4.1.5-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүд улирал бүрийн дараа сарын 20-ны дотор Хороонд ирүүлэхээр зохион байгуулж ажиллахыг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С. ДАВААСҮРЭН